



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/820

Булган сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Засгийн газрын 2025 оны 120 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Нэгдсэн эмнэлэг (РД:9011161)-т Булган сумын 6 дугаар баг Л.Энэбиш 1 дүгээр гудамж 101а тоотод байршилтай 4329971 төлөвлөлтийн дугаартай 1977 м2 газрыг эрүүл мэндийн байгууллагын зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Аймгийн Нэгдсэн эмнэлэг (Б.Шижирбаатар)-тэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг аймгийн Нэгдсэн (Б.Шижирбаатар)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР